



2020 оны 04 сарын 13-ны өдөр

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 19 ДҮГЭЭР ХОРООНЫ ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020 оны 04-р сарын 13-ны өдөр

Дугаар 06/44

Улаанбаатар хот

### Ажлын цар хэмжээ:

Энэхүү ажил нь иргэдэд аюулгүй, тохилог орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

Хан-уул дүүргийн 19 дүгээр хорооны иргэдийн амьдрах орчныг сайжруулах тохижилтын ажлыг Монгол Улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНБД, Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-н эмхтгэл болон холбогдох хууль, дүрэм, журам зааврын дагуу хийж гүйцэтгэх.

Иргэдийн амьдрах орчныг сайжруулах тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах.

Техникийн тодорхойлолтонд тусгагдсан материалын чанар, үзүүлэлт зэргийг хатуу баримтална.

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 3-р сарын 25-ны өдрийн А/410 захирамж
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- ХУД-н 19-р хороо Орчлон хотхонд
3	Зориулалт хүчин чадал	- Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай
4	Одоогийн байдал	- Хуучин талбайн тохижилт муу - Эвдэрч муудсан тоглоом хүүхдийн аюулгүй байдал хангахгүй
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно
6	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан гадна тохижилт хийх тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж оролцох боломжтой.
8	Зураг төсөв боловсруулах үе шат	- Байршилын судалгаа хийх - Загвар зураг боловсруулах/ Нүүр хуудас батлагдах/ - Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/
9	Төсөл гүйцэтгэх үе шат	- Одоо байгаа саравч, тоглоом тоног төхөөрөмжийг засаж сайжруулж зөвөрлөж суурилуулах - Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах

		<ul style="list-style-type: none"> <li>- Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийг суурилуулж угсрах</li> </ul>
10	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<p><b>Тоглоомын талбай:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Иж бүрэн хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж</li> <li>- Тоглоомын талбайн стандарт болон норм, норматив MNS ISO8124-1:2011, MNS ISO8124-2:2011, MNS ISO8124-3:2011, MNS ISO8124-4:2011</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан стандартын шаардлага хангасан орчинг бүрдүүлэх</li> <li>- Тоглоомын аюулгүй байдлын стандартыг хангах</li> </ul> <p><b>Ногоон байгууламж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Одоо байгаа мод, бут, сөөгийг гэмтээхгүй шинээр Монгол орны уур амьсгалд тохирсон шилмүүст болон навчтэй мод, бут, сөөг, зүлэг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх</li> </ul> <p><b>Бусад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тохижилтыг орчны архитектур орон зайн төлөвлөлттэй уялдуулан хайс хашилага, хогийн сав (ангилан ялгах), сандал, саравч гэх мэт архитектурын жижиг хэлбэрүүдийг төлөвлөх</li> </ul>
11	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b>Монгол Улсын хуулиуд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Барилгын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Усны тухай хууль</li> <li>- Бусад холбогдох хууль</li> </ul> <p><b>Төсөл хөтлбөрүүд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага</li> </ul> <p><b>Норм, нормативууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбд30-01-04/</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбд/ 3.01-06-90/</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>
12	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны байгууламжуудтай нэгдсэн байдаар иж бүрэн шийдвэрлэх</li> </ul>
13	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>
14	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх</li> <li>- Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-н эмхтгэл мөрджэж ажиллах</li> <li>- Эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын байгууллагаар баталгаажсан цогцолбор тоглоом төлөвлөх</li> </ul>

- Ажил гүйцэтгэх явцдаа байнга фото зургаар баталгаажуулан ил, далд ажлын акт үйлдэнэ.
- Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээн засварлаж хэвийн байдалд оруулах.
- Гүйцэтгэгч компани өөрсдийн ажилчдын хөдөлмөр аюулгүй байдлыг бүрэн хангаж, онцгой хурц үнэр, тоосжилттой материалыаас аль болох татгалзах.


- Ямарч материалыг сонгохдоо БНБД-д заасан буюу хүүхдэд аюул хоргүй, чанарын өндөр шаардлагатайг нь сонгох ба зөвшөөрөгдсөн /лабораторийн, гарал үүслийн, сертификаттай/ баталгаат материалыг ашиглах.
- Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж ажиллах.

ХЯНАСАН :

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ :

.....Л.ОТГОНБАЯР

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ,  
НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА :



.....Ц.БАТ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН :

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН : .....

.....О.МӨНГӨНШАГАЙ

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 19 ДУГЭЭР ХОРООНЫ ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫГ  
САЙЖРУУЛАХ ТОХИЖЛТИЙН АЖИЛ**



Иргэдийн амьдрас орчныг  
сайжруулж тохижилтийн эхийг  
/ХУД 19 дүгээр хороо/